



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар A/126

Өмнөдэлгэр сум

**Газрын дуудлага худалдааг
хүчингүй болгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 10 дугаар зүйлийн 10.1.2, 15 дугаар зүйлийн 15.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар тогтоолын 4, 5, 7, 8, 9, 13 дугаар хавсралтуудад батлагдсан 4977721, 4980562, 4982241, 4980564, 5020808, 4977720, 4977782, 4980563 төлөвлөлтийн нэгж талбарын дугаар бүхий газруудыг сумын Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн A/68 дугаар захирамж гарган, газрын биржийн цахим (mle.mn) системээр дуудлага худалдааг зохион байгуулж, амжилтгүй болсон тул дуудлага худалдааг хүчингүй болгосугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2026 оны 03 дугаар сарын 09-ний A/68 дугаар захирамжийн 1-6, 8, 9 дахь хэсгүүдийг хүчингүйд тооцугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.

